



“МИАТ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Г.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 03/29 УАГ-САГ/2013/23 /ЖТА-ТӨУГ

Зөрчил арилгуулах тухай

“МИАТ” ТӨХК-ийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Удирдах албан тушаалын нэр бүхий 22 ажилтанд үндсэн цалингийн жишгээс өндөр цалин олгосон бөгөөд цалингийн зөрүү 512.3 сая, нийгмийн даатгалын шимтгэл 66.6 сая, нийт 578.8 сая төгрөгийн зардал гарсан байна.
2. Бүхээгийн үйл ажиллагааны хэлтэст агаарын хөлгийн үйлчлэгчээр 2010 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2012 оны 02 дугаар сарын хооронд үндсэн ажилтнаар томилогдсон нийт 8 ажилтанд цалингийн зөрүү 2010 онд 1.5 сая, 2011 онд 6.7 сая төгрөг, нийт 8.2 сая төгрөгийг тооцож олгосон байна.
3. Компанийн “Орон сууцны үнийн дэмжлэгээр урамшуулах журам”-д тогтвор суурьшилтай үр дүнтэй ажиллах, ажилласан жил нь 5-н жилээс дээш байх гэсэн заалтыг зөрчиж, 4.5 жил ажилласан Захиргаа эрх зүйн газрын Ёс зүйн менежер О.Оч-Эрдэнэд 20.0 сая төгрөгийн орон сууцны үнийн дэмжлэг олгосон ба уг дэмжлэгийг аваад О.Оч-Эрдэнэ ажлаас гарсан байна.
4. ТУЗ-ийн шийдвэргүйгээр Гүйцэтгэх захирал Ц.Орхонд 5.0 сая төгрөгийн шагнал олгосон нь байна. (Гүйцэтгэх захирал өөрөө тушаал гарган өөрийгөө шагнасан)
5. ТӨХ-ны зөвшөөрөлгүй Зам тээврийн яамны Дэд сайд болон Төрийн нарийн бичгийн даргын өрөөний засварын ажлыг хэтэрхий өндөр буюу 148.2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
6. “Орон сууцны үнийн дэмжлэгээр урамшуулах журам”-ын “Өмнө нь системийн байгуулагаас байр, байрны дэмжлэг тусламж аваагүй байх” гэсэн заалтыг зөрчиж нэр бүхий 10 ажилтанд 190.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.
7. Москва, Бээжин, Хонг-Конг, Берлин, Сөүл зэрэг төлөөлөгчийн газрууд төсөвт зардлыг 92.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Дээрхи зөрчлүүд нь Үндсэн хуулийн 14-р зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил,

070084



албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

Хөдөлмөрийн тухай хуулийн 5-р зүйлд “Ажил олгогч хөдөлмөрийн үр дүнд тохирсон хөлс олгох”,

Хөдөлмөрийн тухай хуулийн 7-р зүйлд “Хөдөлмөрийн харилцаанд давуу байдал олгохыг хориглох”,

Хөдөлмөрийн тухай хуулийн 62-р зүйлд “Ажил олгогч нь нийт ажилтны цалин хөлсний хэлбэр, хэмжээг мөрдөж эхлэхээс 10, түүнээс дээш хоногийн өмнө мэдэгдэж, хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулах бөгөөд зөвхөн “хөдөлмөрийн нормоо биелүүлээгүй нь ажилтны буруугаас шалтгаалаагүй бол гүйцэтгэсэн ажилд нь ногдох хөлс болон үндсэн цалингийн зөрүүг нөхөн олгоно”,

ТУЗ-ийн 2002 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 55/1 дугаар тогтоолоор баталсан “Төлөөлөгчийн газрын дүрэм”-ийн 1.6-д “Жилийн төсвийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлана. Төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах үүргийг ерөнхий төлөөлөгч хүлээнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-д “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.4-т “Ажилтнуудад цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмж илүү олгосон, 2.1.2-т “Зохих шийдвэргүйгээр төрийн өмч, хөрөнгийг бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн”, 3.1.6-д “Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, зарлагыг хэтрүүлсэн, зориулалт бусаар зарцуулсан”, 3.1.1-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, албан шаардлага өгөх нь тухайн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус шаардлагын 1, 2, 3, 4, 6 дахь заалтад тусгагдсан зөрчлийн төлбөрийг холбогдох этгээдүүдээр нөхөн төлүүлж компанийг хохиролгүй болгох
2. Цаашид дээрхи алдаа, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүйгээр ажлаа зөв зохион байгуулж ажиллахыг “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Жаргалсайхан, Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга Д.Батбилэг, Ерөнхий нягтлан бодогч Д.Гансайхан нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.
3. Албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2013 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг мэдэгдэе.

Аудитор



Д.Гандолгор